

Чанараа сайжруулах уу?

Ной Хау

Европын Холбооны санхүүжилтээр бид Монголын аялал жуулчлалын тэргүүлэх компанид менежментийн үйл ажиллагаагаа болон үйлчилгээний чанараа сайжруулахад нь тусалсан бөгөөд үр дүнд нь жилийн борлуулалт өсч үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна.



European Bank
for Reconstruction and Development

Монголын аялал жуулчлалын тэргүүлэх компани

Бид аялал жуулчлалын компанид ажилчид болон зочдодоо аюулгүй ажиллах орчныг бүрдүүлж, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахад нь тусалсан. Төсөл хэрэгжсэнээр компанийн жилийн борлуулалт 10 хувиар нэмэгдэж, чанар, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, үйлчилгээний стандарт сайжирсан.

2002 онд байгуулагдсан Нью Жуулчин Турс компани нь Монгол улсын дотоод болон гадагшаа чиглэсэн аялал жуулчлалын тэргүүлэх компаниудын нэг юм. Тус компанийн Ерөнхийлөгч бөгөөд үүсгэн байгуулагч Ш. Нэргүй нь аялал жуулчлалын салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрбээр, дэлхийн түвшний үйлчилгээг байгууллагын болон хувийн аялагчдад үзүүлдэг өндөр түвшний мэргэжлийн менежментийн багийг тэргүүлэн ажилладаг.

Бидний зохион байгуулсан Ноу-Хау арга хэмжээний дараа 2016 онд тус компани бидэнд хандсан.

Нью Жуулчин компани нь олон улсын стандартын дагуу хамгийн шилдэг үйлчилгээг үзүүлж, соёл уламжлалаа дээдэлсэн, дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээтэй, байгаль орчинд ээлтэй нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч аялал жуулчлалын загвар компани болохыг зорин ажилладаг.



Нью Жуулчин турс компани ISO 9001:2008 in сертификатыг 2016 оны 6 сард гардан авлаа.

Тус компанид хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагууд 18001 (OHSAS 18001) стандартыг хэрэгжүүлэхээр дотоодын зөвлөх Эс Эф Си Эс компантай холбож өгсөн.

Зөвлөхийн хийсэн ажлууд:

- Компанийн одоогийн бизнесийн үйл ажиллагаа болон Ажлын байрны, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны цуврал үнэлгээ 18001 (OHSAS 18001) стандартын дагуу Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежментийн тогтолцоог нь шинжлэн судалсан.
- Шинжилгээ судалгааны үр дүнд тулгуурлан ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны цуврал үнэлгээ 18001 (OHSAS 18001) стандартыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулсан.
- Менежментийн болон төслийн багуудад зориулсан сургалтыг хийсэн.
- Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны цуврал үнэлгээ стандартын бодлого болон журмыг боловсруулахад нь төслийн багийг дэмжин ажилласан.
- Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдлийн үнэлгээний хэрэгжилт болон үнэлгээний шинэ журмыг бий болгосон
- Осол гэмтлийн эрсдлийг бууруулах тал дээр төслийн багийг дэмжин ажилласан
- Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны цуврал үнэлгээ 18001 (OHSAS 18001) стандартын дотоод аудит хийж үнэлгээ өгсөн.

Төсөл хэрэгжиж дууссанаас хойш, Нью Жуулчин Турс компани чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2008 хэрэгжүүлж, гэрчилгээ авсан бөгөөд, ингэснээр үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлж, зах зээл дээрх компанийн нэр хүнд өссөн.

Жилийн борлуулалт

+10%

Хөдөлмөрийн бүтээмж

+5%

Ажилчид

+5%

Үйлчлүүлэгчийн зүгээс
оруулсан хувь нэмэр

4,715 евро

Төслийн нийт үнэ цэнэ

9,430 евро

www.ebrd.com/knowhow

